## ДА ХҮРЭЭ ТРЕЙД ХХК

# “АВТО ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН




**БАЙРШИЛ: УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 9-Р ХОРООНЫ НУТАГ**

## АГУУЛГА


**НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ---------- 1**

1.1. Төслийн товч танилцуулга ---------- 1
1.2. Цахилгаан ---------- 2
1.3. Дулаан хангамж ---------- 2
1.4. Усан хангамж ---------- 2
1.5. Ариун цэврийн байгууламж ---------- 2
1.6. Хог хаягдал ---------- 3
1.7. Галын аюулгүй байдал ---------- 4

**ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ---------- 5**

2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах ---------- 5
2.2. Усны зохистой хэрэглээ ба нөөц баялгийг хамгаалах ---------- 5
2.3. Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах, арга хэмжээ ---------- 6
2.4. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт ---------- 6
2.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ---------- 11
2.6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ---------- 11

**ГУРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ---------- 12**

3.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ ---------- 12
3.2. Хөрсний чанарын хяналт шинжилгээ ---------- 12
3.3. Усны чанарын хяналт шинжилгээ ---------- 15

**ДӨРӨВ. БОМТ-г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ---------- 17**

4.1. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ---------- 17
4.2. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт ---------- 17

**ХАВСРАЛТ ---------- 18**

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Эзэмшлийн нийт талбай ---------- 1
Зураг 3. Үйлчилгээний байран дахь худаг---------- 2
Зураг 3. Бохирын цооног ---------- 2
Зураг 4. Ариун цэврийн байгууламж ---------- 3
Зураг 5. Ангилан ялгасан хог хаягдлын сав ---------- 3
Зураг 6. Галын түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, дадлагын үйл явц ---------- 4
Зураг 7. Агаарын чанарын хэмжилт ---------- 5
Зураг 8. Дээврийн ус хуримтлуулах сав ---------- 6
Зураг 9. Мод, сөөг тарьж буй байдал ---------- 10
Зураг 10. Бохирын цооногийн гадаргууг засварлах, будаж буй ажлын явц ---------- 11
Зураг 11. Ариутгал халдваргүйжүүлэх ажил---------- 11
Зураг 12. Хөрсний дээж (2025.07.30) ---------- 12
Зураг 13. Хөрсний дээж (2025.10.08) ---------- 13
Зураг 14. Хөрс, усны дээж авсан байршил ---------- 15
Зураг 15. Ундны усны шинжилгээний дээж ---------- 16

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Мод бут, сөөг тарих чиглэлээр ---------- 7
Хүснэгт 2. Хайрцагтай мод тарьж ургуулах, арчлах ажлын хүрээнд ---------- 8
Хүснэгт 3. Зүлэгжүүлэлтийн ажлын хүрээнд ---------- 8
Хүснэгт 4. Цэцгийн мандал тарьж, байршуулах---------- 9
Хүснэгт 5. Агаарын чанарын шинилгээний дүн---------- 12
Хүснэгт 6. Хөрсний химийн задлан шинжилгээний дүн ---------- 13
Хүснэгт 7. Хөрсний механик бүрэлдэхүүн ---------- 14
Хүснэгт 8. Хөрсний чанарын шинжилгээний дүн ---------- 14
Хүснэгт 9. Ундны усны шинжилгээний дүн (2025.07.29) ---------- 16
Хүснэгт 10. Ундны усны шинжилгээний дүн (2025.10.08) ---------- 16

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Төслийн товч танилцуулга

“Да хүрээ” авто худалдааны төв нь БЗД-ийн 9-р хорооны нутаг дэвсгэрт 6.5 га талбайд худалдаа үйлчилгээний 5 байр, битүү болон задгай авто худалдааны төв, сэлбэгийн дэлгүүр, зоогийн газар зэрэг 200-аад барилга байгууламж, стандартын дагуу засаж тохижуулсан авто машин худалдаалах 1500, үйлчлүүлэгчдийн 300 гаруй зогсоолтойгоор, байгаль орчинд ээлтэй 100 хувь “Эко” орчныг бүрдүүлэх хэтийн зорилготойгоор ажиллаж байна.

Дэд бүтцээс алслагдсан байдал, газар ашиглалт, гудамж замын сүлжээ, үйлчилгээний таатай орчин, хөрс агаарын бохирдлыг бууруулах зэрэг тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхээр Улаанбаатар хотын 2020-2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, “Шархад дэд төв”-ийн төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан “Да хүрээ” авто худалдааны төв байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний дагуу “Үйлчилгээтэй 2 давхар дулаан зогсоол”-ын барилга угсралтын ажлыг 2019 онд эхлүүлж ашиглалтад оруулсан.

Тус төсөл нь худалдаа үйлчилгээний барилгуудыг иж бүрнээр нь төлөвлөж, авто зам, ногоон байгууламжийг гэр хорооллын бүсэд нэмэгдүүлэн, хотын эдийн засаг, дэд бүтцийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахын зэрэгцээ эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрэлдэх олон талын ач холбогдолтой юм.

Байгаль орчны зөвлөх үйлчилгээний эрх бүхий мэргэжлийн байгууллага болох “Эко Цогц Шийдэл” ХХК-тай холбогдох хууль тогтоомжийг үндэслэн байгуулсан гэрээний дагуу 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг боловсруулсан.

Зураг 1. Эзэмшлийн нийт талбай



### 1.2. Цахилгаан

Цахилгаан эрчим хүчийг Улаанбаатар хотын нэгдсэн сүлжээнээс хангадаг. БЗД-ийн 9 дүгээр хороонд байрлах “Да хүрээ трейд” ХХК-ийн эзэмшилд Улаанхуаран дэд станцын Манлай фидерийн КТПН-3558 дэд өртөөний 10/400 кВА хүчин чадал бүхий трансформатор, Шар хад фидерийн КТПН-5836 дэд өртөөний 10/630 кВА хүчин чадал бүхий трансформаторуудтай.

Тус аж ахуйн нэгж нь цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ зэргийг удирдлага болгон, мөрдөж ажилладаг бөгөөд сарын цахилгаан эрчим хүчний дундаж хэрэглээ 170,000 кВт.ц (дундаж хэрэглээг 2ш КТПН-ийн жилийн тоолуурын заалтыг хувилж тооцож гаргасан) байдаг.

### 1.3. Дулаан хангамж

Оффис болон үйлчилгээний зориулалт бүхий барилга байгууламжуудыг “Дакон” брендийн цахилгаан 60, 48, 24 кВт-ын цахилгаан зуухаар халаадаг.

### 1.4. Усан хангамж

УСУГ-тай хийсэн гэрээний дагуу 17-р хорооны цэвэр усны худгаас шугам татуулан усны нөөцлүүр бүхий саванд цуглуулж хэрэглээний төлбөрийг тоолуурын заалтаар барагдуулдаг.

Зураг 3. Үйлчилгээний байран дахь худаг



Зураг 3. Бохирын цооног



### 1.5. Ариун цэврийн байгууламж

Тус худалдааны төвийн “Худалдаа үйлчилгээ”-ний 5 байран дотор 6, хашаан дотор 2, нийт 8 ариун цэврийн стандартын шаардлага хангасан бие засах өрөөг

байгуулан, бохирын цооногт хуримтлуулан, эрх бүхий байгууллагуудтай хийсэн гэрээний дагуу шингэн хаягдлыг зайлуулж ажилладаг.

Тухайлбал, “Голден Эко” ХХК-тай бохир ус тээвэрлэлтийн 22/07 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна.

Зураг 4. Ариун цэврийн байгууламж




### 1.6. Хог хаягдал

Үйлчилгээний төв болон худалдаа эрхлэгчдээс гарах өдөр тутмын хог хаягдлыг ангилан ялган зориулалтын хогийн саванд байршуулж дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар IV- ийн гэрээт байгууллага болох хог тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг “Үйлст Мандал” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу зайлуулдаг.

Зураг 5. Ангилан ялгасан хог хаягдлын сав



## 1.7. Галын аюулгүй байдал

Тус авто машин худалдааны төвд нийтдээ 34 байршилд галын аюулгүй байдлын хамгаалах хэрэгслүүдийг онцгой байдлын албанаас өгсөн зөвлөмжийн дагуу байршуулж, галын хорын аюулгүй ажиллагаа, хүчинтэй хугацааг хянаж гал түймрийн аюулгүй байдлын үед авах арга хэмжээний талаар дүүргийн Онцгой байдлын албатай хамтран ажилчдад жил бүр сургалт зохион байгуулдаг.

Гал унтраах багаж хэрэгсэлд үзлэг хийсэн бүртгэлийн хуудсыг хавсралтад тусгав.

Зураг 6. Галын түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, дадлагын үйл явц



## ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

“Да Хүрээ” авто худалдааны төв нь дулаан хангамжийн эх үүсвэрийг “Дакон” брэндийн цахилгаан зуухаар халаадаг тул агаарын чанарт галлагаанаас үүдэлтэй сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Орчны тоосжилтыг багасгах үүднээс ногоон байгууламж, зам талбай зүлэгжүүлэх ажлыг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гүйцэтгэсэн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус захын бетон хучилтгүй авто зогсоолын ойролцоо агаарын чанарын үндсэн үзүүлэлтийг 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдөр болон 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд хийж гүйцэтгэхэд MNS 4585:2025 үзүүлэлтээс давсан бохирдлын зэрэг тодорхойлогдоогүй байна.

Зураг 7. Агаарын чанарын хэмжилт





### 2.2. Усны зохистой хэрэглээ ба нөөц баялгийг хамгаалах

Тус төвийн усны хэрэглээ нь зөвхөн ажилчдын ахуйн болон ундны усны хэрэглээ байдаг.

Хэрэглээний ус болох гадна талбайг чийгшүүлэх, ногоон байгууламж услахад борооны усыг хуримтлуулж түүгээр усалгаа хийх ажлыг гүйцэтгэсэн.

Борооны ус хуримтлуулах савыг 8 байршилд дээврийн усны хаялгаас шууд хураах байдлаар суурилуулж, нийт 5 тн ус хуримтлуулах савыг ногоон байгууламжийн усалгаа, зам талбайн чийгшүүлэлтэд ашигласан.

Зураг 8. Дээврийн ус хуримтлуулах сав






## 2.3. Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах, арга хэмжээ

Шатах тослох материал асгарахаас сэргийлэх, алдагдах тохиолдолд саармагжуулах аргачилсан зааврыг боловсруулж, ажиллагсдад танилцуулан, мэдээллийн самбарт байршуулсан.

Хөрсний бохирдлын шинжилгээг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тогтоосон байршилд 2 удаа дээж авч итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлэн шинжлүүлсэн.

## 2.4. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт

Худалдааны төвийн ногоон байгууламжийн арчилгаа, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх ажлын 2025 оны 5 дугаар сард дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Худалдааны төвийн 7 байршлын 10 хэсэгт 690 ширхэг хайлаас тарьсан.
2. Худалдааны төвийн ногоон байгууламжийн 4 байршилд агч 2, монос 6, голт бор 19, сакура 3, гацуур 4 ширхэгийг нэмж тарьсан.
3. Зам талбайн тохижилтын ажлын хүрээнд 19 байршилд 710 $м^2$ талбайд зүлгийн үр тарьсан.
4. Орчны өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд 17 байршилд 48 цэцгийн саванд 358 ширхэг цэцэг суулган тарьсан. Мөн 14 саванд үрээр үрсэлгээ хийж цэцгийн мандал тарьсан.
5. Зам талбайн орц гарцын тэмдэглэгээг хийж гүйцэтгэсэн байна.

Худалдааны төвийн 27 байршилд:

- Жижиг хайрцагтай мод - 28 ширхэг
- Том хайрцагтай мод 87 – ширхэг

- Голт бор – 151 ширхэг
- Тэхийн шээг – 105 ширхэг
- Боролзгоно – 184 ширхэг
- Шар хуайс, хайлаас – 1202 ширхэг
- Улиас – 66 ширхэг
- Хус – 2 ширхэг
- Хар мод – 1 ширхэг.

Нийт 7 төрлийн 1711 ширхэг мод тарьсан байна. 16 байршилд 34 хайрцагт 161 бут буюу 500 ширхэг хайлаасаар нөхөөс хийсэн.

Хүснэгт 1. Мод бут, сөөг тарих чиглэлээр

| № | Байршил | Модны нэр | Тарьцын тоо | | Суулгах модны нэр |
|---|---|---|---|---|---|
| | | | V/09 | V/13 | |
| 1-р төвийн гадна талд | | | | | |
| 1. | Жижиг хайрцагт | Голт бор | 1 | | |
| 2-р төвийн гадна талд | | | | | |
| 2. | Баруун тал | Шар хуайс | 25 | | |
| 3. | Зүүн тал | | 25 | | |
| 4. | Ногоон байгууламж | Голт бор | 2 | | |
| | Аж ахуйн хашааны урд талд | | | | |
| 5. | Зүүн тал | Шар хуайс | 30 | | |
| | 6-р хаалганы гадна талд | | | | |
| 6. | Шар хуайс | | 60 | | |
| 7. | Авто салоны урд талд | Шар хуайс | 1 | | |
| 8. | 5-р төвийн урд талд | Шар хуайс | 4 | | |
| | 2-р хаалганы гадна талд | | | | |
| 9. | Баруун урд тал | Голт бор | 13 | | Агч-1<br>Монос-3<br>Голт бор-9 |
| | | Шар хуайс | 70 | | |
| | 3-р хаалганы гадна талд | | | | |
| 10. | Баруун урд тал | Шар хуайс | 80 | | |
| | | Голт бор | 10 | | Агч – 1<br>Монос -3<br>Голт бор-5 |
| 11. | Авто центр баруун хаалга | Голт бор | 1 | | |
| Авто салон | | | | | |
| 12. | Баруун, зүүн талд | Гацуур | 4 | | Гацуур – 4<br>Сакура – 1 |
| | | Голт бор | 2 | | |
| 3-р төв хойд талд | | | | | |
| 13. | Зүүн тал | Шар хуайс | 110 | 24 | |
| 14. | Баруун тал | | 40 | | |
| 15. | Ногоон байгууламж | Голт бор | 1 | | |
| Задгай салон | | | | | |
| 16. | Баруун тал | Шар хуайс | 150 | 47 | |
| 17. | Зүүн тал | Шар хуайс | 100 | 217 | |
| | | Голт бор | 1 | | Сакура-2<br>Голт бор-5 |
| **Нийт:** | | | **Хайлаас -690 ш, голт бор -10ш** | | |

Хүснэгт 2. Хайрцагтай мод тарьж ургуулах, арчлах ажлын хүрээнд

| № | Байршил | Хайрцаг | | Суулгац | Тоо ширхэг |
|---|---|---|---|---|---|
| 1. | Захиргааны урд | Жижиг хайрцаг | 1 хайр | 6 бут | 18ш |
| 2. | | Жижиг хайрцаг | 1 хайр | 6 бут | 18ш |
| 3. | | Урт хайрцаг | 1 хайр | 3 бут | 9ш |
| 4. | Тамхины цэгийн хажууд | Жижиг хайрцаг | 1 хайр | 4 бут | 12ш |
| 5. | Мак-ийн зам дагуу | Урт хайрцаг | 1 хайр | 3 бут | 9ш |
| 6. | | Жижиг хайрцаг | 1 хайр | 6 бут | 18ш |
| 7. | Хойд зам дагуу | Урт хайрцаг | 4 хайр | 12 бут | 36ш |
| 8. | 7-р хаалганы гадна | Урт хайрцаг | 3 хайр | 30 бут | 90ш |
| 9. | Баруун талбайн тугны суурины дэргэд | Жижиг хайрцаг | 2 хайр | 8 бут | 24ш |
| 10. | 28 эгнээ хашаа дагуу | Урт хайрцаг | 3 хайр | 30 бут | 90ш |
| 11. | Аккумляторын эгнээнд | Жижиг хайрцаг | 6 хайр | 18 бут | 54ш |
| 12. | Сургалтын танхимын үүдэнд | Жижиг хайрцаг | 1 хайр | 3 бут | 9ш |
| 13. | Задгай салон урд | Жижиг хайрцаг | 2 хайр | 6 бут | 18ш |
| 14. | Өлзийт | Урт хайрцаг | 3 хайр | 6 бут | 18ш |
| 15. | ХАА-н эгнээний хажууд | Жижиг хайрцаг | 2 хайр | 8 бут | 24ш |
| 16. | ХҮ-ний 5-р байрны хойно | Жижиг хайрцаг | 2 хайр | 12 бут | 36ш |
| | 16 байршилд | | 34 хайр | 161 бут | 483 ширхэг |

Хүснэгт 3. Зүлэгжүүлэлтийн ажлын хүрээнд

| № | Талбайн байрлал | | Хэмжээ /м²/ | Нийт хэмжээ /м²/ | Нөхөн сэргээлт хийх |
|---|---|---|---|---|---|
| 1. | 2-р хаалга | Хойд тал | 286 | 583 | 120 |
| | | Урд тал | 297 | | 110 |
| 2. | ХҮ-ний 3-р төвийн ар талд | Баруун талбай | 106,6 | 153,75 | 60 |
| | | Зүүн талбай | 47,15 | | 30 |
| 3. | Авто центрийн зүүн талд | | 53 | | 5 |
| 4. | Авто центрийн баруун талд | | 16 | | 2 |
| 5. | Цэнхэр саравч /задгай салон/-ны урд | 1-р хэсэг | 70 | 494 | 70 |
| | | 2-р хэсэг | 135 | | 25 |
| | | 3-р хэсэг | 150 | | 30 |
| 6. | 5-р постын дотор тал | | 70 | | 20 |
| 7. | Авто салоны урд | Баруун | 78,4 | 132.3 | 15 |
| | | Зүүн | 53,9 | | 10 |
| 8. | 1-р хогийн цэгийн хажууд | | 8 | | 4 |
| 9. | ХҮ-ний 2-р төвийн урд | 1-р хэсэг | 34,7 | 81.7 | 15 |
| | | 2-р хэсэг | 14 | | 15 |
| | | 3-р хэсэг | 20 | | 10 |
| | | 4-р хэсэг | 5 | | 10 |
| 10. | ХҮ-ний 1-р байрны урд | | 24,7 | | 15 |
| 11. | ХҮ-ний 1-р байрны зүүн талд | | 60,5 | | 10 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12. | АА-н хашаа | Баруун | 3,9 | **122.6** | 5 |
| | | Зүүн | 14,5 | | 5 |
| 13. | | Манду хаус цонх дагуу | 19 | | 19 |
| 14. | Өлзийтийн эгнээний хажууд | | 22,16 | | 15 |
| 15. | 5-р хаалганы хажууд | | 13 | | 15 |
| 16. | 1-р уурын зуухны хажууд | | 3,5 | | 3 |
| 17. | НБЗГ 1 | Үүдэнд | 30 | **68.66** | 2 |
| | | Хажууд | | | 30 |
| | | Ар талд | | | 10 |
| 18. | 6-р хаалганы гадна ногоон байгууламж | | 54,18 | | 20 |
| 19. | 2-р уурын зуухны хажууд /шинэ/ | | 6 | | 10 |
| | | | | 60.18 | |
| | | | Нийт | 1696,19м$^2$ | 710м$^2$ |

Хүснэгт 4. Цэцгийн мандал тарьж, байршуулах

| № | Байршил | Цэцгийн сав | Савны тоо | Цэцгийн тоо |
|---|---|---|---|---|
| 1. | ХҮ-ний 1-р байр | Өндөр саарал | 2ш | 16ш |
| 2. | | Урт саарал | 2ш | 18ш |
| 3. | Хөшөөний урд | Жижиг ногоон | 6ш | 24ш |
| 4. | Тугны суурины доор | | | 15ш |
| 5. | ХҮ-ний 2-р байр | Бөөрөнхий шаргал | 2ш | 15ш |
| 6. | ХҮ-ний 3-р байр | Бөөрөнхий хар | 4ш | 26ш |
| 7. | ХҮ-ний 4-р байр | Урт бор | 2ш | 16ш |
| 8. | Задгай салон | Бөөрөнхий хар | 4ш | 40ш |
| 9. | Усан оргилуур | Урт шар | 9ш | 72ш |
| 10. | | Бөөрөнхий цагаан | 2ш | 19ш |
| 11. | | Урт цагаан тавиур | 4ш | 40ш |
| 12. | ХҮ-ний 5-р байр | Бөөрөнхий хар | 2ш | 13ш |
| 13. | | Бөөрөнхий ягаан | 2ш | 14ш |
| 14. | НБЗГ-I | Бөөрөнхий | 2ш | 12ш |
| 15. | НБЗГ-II | Урт бор | 2ш | 12ш |
| 16. | ХТ-ийн 5-р постын хашаанд | Бөөрөнхий цагаан | 2ш | 78ш |
| 17. | | Бөөрөнхий бор | 1ш | |
| 18. | | | 48ш | 358ш |

Зураг 9. Мод, сөөг тарьж буй байдал



## 2.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Худалдааны төвийн эзэмшлийн талбайд түүх соёлын дурсгалт зүйлс болон археологи, палеонтологийн олдвортой газар байхгүй.

## 2.6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр хогийн савуудыг засаж сэлбэх, халдваргүйжүүлэх, зарим байршилд шинээр хогийн сав байршуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хортон шавжаас хамгаалах, ариутгал халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа “Жаргалант” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж, дахивар хог хаягдлыг тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “ЭС И Эс Эл Смарт Солюушн” ХХК, бохир ус тээвэрлэх, зайлуулах ажлыг “Голден Эко” ХХК-тай хийсэн гэрээний дагуу тус тус гүйцэтгэсэн байна.

Зураг 11. Ариутгал халдваргүйжүүлэх ажил



Зураг 10. Бохирын цооногийн гадаргуун засварлах, будаж буй ажлын явц



## ГУРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсанаар орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчны хяналт шинжилгээг 2025 оны 07-р сарын 29, 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд тус тус хийж гүйцэтгэсэн.

### 3.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ

Баянзүрх дүүргийн 9-р хороонд байрлах худалдааны төвийн бетондож хучилт хийгдээгүй хайрга давхарга бүхий авто зогсоолын орчмоос агаар бохирдуулагч үндсэн хий болох азот, хүхэрлэг хий болон тоосонцрын дээжийг соруулан авч орчны нөлөөллийг үнэлэв (Зураг 7).

Хүснэгт 5. Агаарын чанарын шинилгээний дүн

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан огноо | Хүхэрлэг хий мг/м$^3$ | Азотын давхар исэл мг/м$^3$ | Нийт тоос /TSP/ мг/м3 | Дуу чимээ /ДБА/ |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | Эзэмшлийн талбай | 2025.07.29 | 9 | 92 | 207 | 62 |
| **2** | | 2025.10.08 | 21 | 103 | 289 | 52 |
| Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 | | | **450** | **200** | **500** | **100** |

Дээрх шинжилгээний дүнгээр агаарын чанар MNS 4585:2025 стандартаас давсан үзүүлэлт тодорхойлогдоогүй байна.

### 3.2. Хөрсний чанарын хяналт шинжилгээ

Орчны хяналт шинжилгээний мониторингийн ажлын хүрээнд хөрсний бохирдлын шинж чанарыг тодорхойлохын тулд худалдааны төвийн эзэмшлийн талбайд 2 цэгээс, хашааны гадна талаас 1 цэгийг сонгон дээж авч Инженер геодези ХХК-д шинжлүүлсэн.

Зураг 12. Хөрсний дээж (2025.07.30)





Зураг 13. Хөрсний дээж (2025.10.08)



Хүснэгт 6. Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

| № | Дээжийн нэр | Гүн | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $NO_3$ мг/100г | CaCO2, % | Шингээгдсэн сууриуд, мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 1 | Хөрс-1 | 0-20 | 9.14 | 0.10 | 0.204 | 0.38 | 0.71 | 0.66 | 4.8 | 4.4 | 0.5 | 18 |
| 2 | Хөрс-2 | 0-20 | 8.62 | 0.11 | 0.234 | 1.96 | 1.16 | 0.66 | 9.5 | 4.2 | 2.3 | 59 |
| 3 | Хөрс-3 | 0-20 | 8.59 | 0.12 | 0.240 | 3.74 | - | 0.49 | 15.8 | 10.0 | 3.8 | 61 |
| 4 | Дээж-1 | 0-20 | 8.14 | 0.41 | 0.828 | 0.18 | 0.11 | 0.32 | 7.1 | 4.4 | 0.7 | 21 |
| 5 | Дээж-2 | 0-20 | 8.06 | 0.09 | 0.181 | 3.13 | 0.59 | 0.16 | 15.9 | 12.6 | 3.0 | 61 |
| 6 | Дээж-3 | 0-20 | 7.88 | 0.12 | 0.259 | 2.66 | 0.44 | 0.16 | 13.0 | 7.0 | 3.8 | 64 |

Хөрсний ялзмаг өнгөн хөрсөнд  дээж авсан цэгүүдийн дунджаар 2.08, хөрсний PH- 8.45 буюу сул шүлтлэг, 100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфор 2.35 мг, солилцох кали 47.3 мг байна. Хөрс шим тэжээлийн бодисын агууламж дундаж хангамжтай байна.

Хүснэгт 7. Хөрсний механик бүрэлдэхүүн

| № | Дээжийн нэр | Гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | Хөрс-1 | 0-20 | 36.8 | 37.4 | 11.4 | 3.7 | 6.2 | 4.6 | 14.5 |
| 2 | Хөрс-2 | 0-20 | 34.8 | 41.7 | 10.3 | 4.1 | 5.9 | 3.2 | 13.2 |
| 3 | Хөрс-3 | 0-20 | 20.0 | 37.8 | 17.9 | 7.7 | 6.8 | 9.7 | 24.2 |
| 4 | Дээж-1 | 0-20 | 65.3 | 16.2 | 9.3 | 3.7 | 2.9 | 2.5 | 9.2 |
| 5 | Дээж-2 | 0-20 | 27.5 | 40.1 | 15.8 | 5.7 | 5.4 | 5.4 | 16.5 |
| 6 | Дээж-3 | 0-20 | 24.9 | 43.3 | 14.9 | 5.9 | 5.5 | 5.5 | 16.9 |

Хөрсний механик шинж чанарын үзүүлэлт элсэнцэр фракц давамгайлсан шинжтэй байна.

Хүснэгт 8. Хөрсний чанарын шинжилгээний дүн

| № | Дээж авсан огноо | Дээжийн нэр | Хүнд металл мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ni /Никель/ | Cd /Кадми/ | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1 | 2025.07.30 | Хөрс-1 | 2.52 | ND | 18.54 | 18.03 | 41.96 | 4.80 |
| 2 | | Хөрс-2 | 17.82 | ND | 52.37 | 88.95 | 127.41 | 26.49 |
| 3 | | Хөрс-3 | 14.69 | ND | 94.08 | 28.39 | 80.36 | 24.60 |
| 4 | 2025.10.08 | Дээж-1 | 11.76 | ND | 37.90 | 36.90 | 105.37 | 19.47 |
| 5 | | Дээж-2 | 10.88 | ND | 27.94 | 16.10 | 107.88 | 5.81 |
| 6 | | Дээж-3 | 14.90 | ND | 198.50 | 42.41 | 124.91 | 16.19 |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/ | | | 150.0 | 3.0 | 100.0 | 100.0 | 300.0 | 150.0 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | | 1000.0 | 10.0 | 500.0 | 500.0 | 600.0 | 400.0 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | | 1800.0 | 20.0 | 1200.0 | 1000.0 | 1000.0 | 1500.0 |

Дээрх шинжилгээний дүнгээс харахад “Да Хүрээ” төвийн эзэмшлийн талбайгаас авсан дээжид хөрсний бохирдлын зэрэг илрээгүй.

Харин эзэмшлийн талбайн гадна талаас 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн “дээж-3” дахь хар тугалгын хэмжээ стандарт үзүүлэлтээс 98.5 мг/кг-аар их гарсан байна.

Зураг 14. Хөрс, усны дээж авсан байршил




Тус шинжилгээний дээж нь орчны хяналт шинжилгээний хүрээнд хийгдсэн 6 дахь дээж бөгөөд (Зураг 14)-д үзүүлснээр худалдааны төвийн хашааны гадна талаас авсан дээжид хамаарах тул тодорхой хяналтгүйгээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчид хог хаягдлыг ил задгай хаяснаас бохирдол үүсэх нөхцөл бий болсон гэж үзэхээр байна.

### 3.3. Усны чанарын хяналт шинжилгээ

“Да Хүрээ” төв нь УСУГ-тай хийсэн гэрээний дагуу 17-р хорооны цэвэр усны худгаас шугам татуулан төв оффисын хойно байрлах худаг дахь усны нөөцлүүр бүхий саванд цуглуулж хэрэглээний цэвэр усыг хангадаг (Зураг 3).

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд тус худгийн уснаас 2025 оны 07 дугаар сарын 29, 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд шинжилгээний дааж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн (Зураг 14).

Зураг 15. Ундны усны шинжилгээний дээж







Хүснэгт 9. Ундны усны шинжилгээний дүн (2025.07.29)

| Анион | мг/л | мг/экв | %, мг-экв/л | Катион | мг/л | мг/экв | %, мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|
| Cl- | 10.64 | 0.30 | 26.27 | $Na^{+}+K^{+}$ | 11.80 | 0.51 | 45 .00 |
| $SO_4^{2-}$ | 4 .07 | 0.08 | 7.43 | $NH_4^{+}$ | 0.20 | 0.01 | 0.97 |
| $NO_3^{-}$ | 9.63 | 0. 16 | 13.62 | $Ca^{2+}$ | 8.02 | 0.40 | 35.08 |
| $N0_2^{-}$ | 0.03 | 0.00 | 0.06 | $Mg^{2+}$ | 2.43 | 0.20 | 17.54 |
| $Co_3^{2-}$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Fe^{2+}$ | 0.30 | 0.02 | 1.41 |
| $HCO_3^{-}$ | 36.61 | 0.60 | 52.62 | $Fe^{3+}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 60.98 | 1.14 | 100.00 | Дүн | 22.75 | 1.14 | 100.00 |

Хүснэгт 10. Ундны усны шинжилгээний дүн (2025.10.08)

| Анион | мг/л | мг/экв | %, мг-экв/л | Катион | мг/л | мг/экв | %, мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|
| Cl- | 10.64 | 0.30 | 21.60 | $Na^{+}+K^{+}$ | 13.00 | 0.57 | 40 .76 |
| $SO_4^{2-}$ | 2.59 | 0.05 | 3.89 | $NH_4^{+}$ | 0.10 | 0.01 | 0.40 |
| $NO_3^{-}$ | 2 .06 | 0.03 | 2.40 | $Ca^{2+}$ | 10.02 | 0.50 | 36.05 |
| $N0_2^{-}$ | 0.01 | 0.00 | 0.02 | $Mg^{2+}$ | 3.65 | 0.30 | 21.63 |
| $Co_3^{2-}$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Fe^{2+}$ | 0.30 | 0.02 | 1.16 |
| $HCO_3^{-}$ | 61.02 | 1.00 | 72.10 | $Fe^{3+}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 76.32 | 1.39 | 100.00 | Дүн | 27.07 | 1.39 | 100.00 |

Дээрх шинжилгээний дүнгүүдээр тус худалдааны төвийн ундны ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат ангин, натрийн бүлгийн 2-р төрлийн, чанарын хувьд нэг цэнгэг буюу ялимгүй эрдэсжилтэй, маш зөөлөн ус гэж тодорхойлогдсон байна.

# ДӨРӨВ. БОМТ-г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 4.1. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу ангилан ялгах, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдэд нийлүүлэх, ил задгай хаяж орчныг бохирдуулахаас сэргийлж анхааруулах самбар, сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Мөн орчны тохижилт, хөл газрын ургамлыг хадах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, дадлагын ажлуудыг удирдлагын болон дотоод санхүүгийн нөөц бололцоог ашиглан гүйцэтгэсэн болно.

## 4.2. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны засаг дарга, хорооны хэсгийн ахлагч болон суурьшлын бүсийн иргэдэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажил, орчны тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд агч 2, монос 6, голт бор 19, сакура 3, гацуур 4, хайлаас 690  ширхэгийг тарьж ургуулан 710 $м^2$ талбайг зүлэгжүүлэн, 48 цэцгийн саванд 358 ширхэг цэцэг суулган тарьж, 14 саванд үрээр үрсэлгээ хийж цэцгийн мандал тарьж “Тэрбум” мод үндэсний хөтөлбөрийг дэмжин ногоон байгууламжийн эзлэх хувийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа талаар танилцуулав.

Мөн тус хорооны удирдлагын зүгээс ажилгүй иргэдийг ажлын байраар хангах талаар ирүүлсэн хүсэлтийг 2 тал харилцан зөвшилцөж, хамтран ажиллахаар тохиролцов.

# ХАВСРАЛТ

**“Да Хүрээ” Авто худалдааны төвийн барилга, байгууламжийн тохижилтын хэсгээс**


















**Иргэд, үйлчлүүлэгчдийн зогсоолын хэсгээс**






## Иргэд үйлчлүүлэгчдэд зориулсан амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх хэсэг






**Ногоон байгууламж, орчны тохижилтын чиглэлээр хийгдсэн ажлуудаас**










## Ногоон байгууламж, орчны тохижилтын чиглэлээр хийгдсэн ажлуудаас








**Ногоон байгууламж, орчны тохижилтын чиглэлээр хийгдсэн ажлуудаас**







**Ногоон байгууламж, орчны тохижилтын чиглэлээр хийгдсэн ажлуудаас**







**Орчны тохижилтын чиглэлээр хийгдсэн ажлуудаас**







**Орчны тохижилтын чиглэлээр хийгдсэн ажлуудаас**








**Орчны тохижилтын чиглэлээр хийгдсэн ажлуудаас**








**Ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлын хэсгээс**







**Ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлын хэсгээс**







ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

# СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2025/A-662 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : “Эко Цогц Шийдэл” ХХК |
| Сорьц авсан хүний нэр, албан тушаал | : Д.Сувд агаарын хэсэг |
| Сорьцын тоо, төрөл | : 1 агаар, 1 дуу чимээ |
| Сорьц авсан огноо | : 2025.07.29 |
| Сорьцын тодорхойлолт | : Улаанбаатар хот БЗД 9-р хороо Да Хүрээ Трейд ХХК |
| Шинжилгээний аргын стандарт | : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021<br>MNS 6768:2019, САЗ А07-2016 |
| Шинжилсэн огноо | : 2025.08.05 |
| Хуудасны тоо | : 1/1 |

Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мкг/м$^3$ | | | ДБА |
| 1 | Гадна талбай | 25/07/29 | 15:00 | 9 | 92 | 207 | 62 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 (20 минутын хэмжилт)** | | | | **450** | **200** | **500** | **100** |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч : Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч: Д.Түмэндэлгэр

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН**
**ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

# СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/A-971
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Эко Цогц Шийдэл" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2025.10.08
Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар хот БЗД 9-р хороо Да Хүрээ Трейд ХХК
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 6768:2019, САЗ А07-2016
Шинжилсэн огноо : 2025.10.10
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мкг/м$^3$ | | | ДБА |
| 1 | Гадна талбай | 25/10/08 | 12:00 | 21 | 103 | 289 | 52 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 (20 минутын хэмжилт)** | | | | **450** | **200** | **500** | **100** |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч : Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч: Д.Түмэндэлгэр

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

# ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

MNAS Accreditation system TL 078 MNS ISO/IEC 17025

**Дугаар: 25/1082**

**Дээж авсан огноо:** 2025 он 07 сарын 30
**Шинжилгээ хийсэн огноо:** 2025 он 08 сарын 02
**Дээж авсан газрын нэр:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 9-р хороо, "Да хүрээ Трейд"-ХХК
**Координат:**
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** "Эко цогц шийдэл" ХХК
**Харилцах утас:** 99074356

## *Хөрсний химийн задлан шинжилгээний дүн*

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $NO_3$ мг/100г | $CaCO_3$,% | Шингээгдсэн суурьууд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элемэнтүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 25/5451 | Хөрс-1 | - | 9.14 | 0.10 | 0.204 | 0.38 | 0.71 | 0.66 | 4.8 | 4.4 | 0.5 | 18 |
| 2 | 25/5452 | Хөрс-2 | - | 8.62 | 0.11 | 0.234 | 1.96 | 1.16 | 0.66 | 9.5 | 4.2 | 2.3 | 59 |
| 3 | 25/5453 | Хөрс-3 | - | 8.59 | 0.12 | 0.240 | 3.74 | | 0.49 | 15.8 | 10.0 | 3.8 | 61 |

## *Хөрсний механик бүрэлдэхүүн*

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 25/5451 | Хөрс-1 | - | 36.8 | 37.4 | 11.4 | 3.7 | 6.2 | 4.6 | 14.5 |
| 2 | 25/5452 | Хөрс-2 | - | 34.8 | 41.7 | 10.3 | 4.1 | 5.9 | 3.2 | 13.2 |
| 3 | 25/5453 | Хөрс-3 | - | 20.0 | 37.8 | 17.9 | 7.7 | 6.8 | 9.7 | 24.2 |

## *Хөрсний хүнд металл*

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | *Хүнд металл мг/кг* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ni /Никель | Cd /Кадми | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1 | 25/5451 | Хөрс-1 | - | 2.52 | ND | 18.54 | 18.03 | 41.96 | 4.80 |
| 2 | 25/5452 | Хөрс-2 | - | 17.82 | ND | 52.37 | 88.95 | 127.41 | 26.49 |
| 3 | 25/5453 | Хөрс-3 | - | 14.69 | ND | 94.08 | 28.39 | 80.36 | 24.60 |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/ | | | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт | | | | /MNS 5850:2019/ | | | | | |

***ND-not detect**

***Жич:** Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS 6988:2022 MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч: Л. Цагаандархи /MS.c/-2

Задлан шинжээч: С. Ганцэцэг

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 78 ҮИТ0049

ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

**Дугаар: 25/1680**

**Дээж авсан огноо:** 2025 он 10 сарын 08
**Шинжилгээ хийсэн огноо:** 2025 он 10 сарын 09-10
**Дээж авсан газрын нэр**: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 9-р хороо, Да хүрээ авто худалдааны төв
**Координат: -**
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** “Эко цогц шийдэл”ХХК
**Харилцах утас:** 99074356

***Хөрсний химийн задлан шинжилгээний дүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $NO_3$ мг/100г | $CaCO_3$,% | Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элемэнтүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 25/8069 | Дээж-1 | - | 8.14 | 0.41 | 0.828 | 0.18 | 0.11 | 0.32 | 7.1 | 4.4 | 0.7 | 21 |
| 2 | 25/8070 | Дээж-2 | - | 8.06 | 0.09 | 0.181 | 3.13 | 0.59 | 0.16 | 15.9 | 12.6 | 3.0 | 61 |
| 3 | 25/8071 | Дээж-3 | - | 7.88 | 0.12 | 0.259 | 2.66 | 0.44 | 0.16 | 13.0 | 7.0 | 3.8 | 64 |

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 25/8069 | Дээж-1 | - | 65.3 | 16.2 | 9.3 | 3.7 | 2.9 | 2.5 | 9.2 |
| 2 | 25/8070 | Дээж-2 | - | 27.5 | 40.1 | 15.8 | 5.7 | 5.4 | 5.4 | 16.5 |
| 3 | 25/8071 | Дээж-3 | - | 24.9 | 43.3 | 14.9 | 5.9 | 5.5 | 5.5 | 16.9 |

***Хөрсний хүнд металл***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | *Хүнд металл мг/кг* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ni /Никель | Cd /Кадми | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1 | 25/8069 | Дээж-1 | - | 11.76 | ND | 37.97 | 36.90 | 105.37 | 19.47 |
| 2 | 25/8070 | Дээж-2 | - | 10.88 | ND | 27.94 | 16.10 | 107.88 | 5.81 |
| 3 | 25/8071 | Дээж-3 | - | 14.90 | ND | 198.50 | 42.41 | 124.91 | 16.19 |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/ | | | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт | | | | /MNS 5850:2019/ | | | | | |

***ND-not detect**

***Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.***

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS 6988:2022, MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч: Л. Цагаандархи /MS.c/

Задлан шинжээч: С. Ганцэцэг

ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ
ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ
ҮИТ0049

## ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

MNAS Accreditation system TL 078 MNS ISO/IEC 17025

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

**Дугаар: 25/1083**

**Дээж авсан огноо:** 2025 он 07 сарын 30
**Шинжилгээ хийсэн огноо:** 2025 он 08 сарын 02
**Дээж авсан газрын нэр**: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 9-р хороо, "Да хүрээ Трейд"-ХХК
**Координат:**
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** "Эко цогц шийдэл" ХХК
**Харилцах утас:** 99074356
**Уст цэгийн төрөл ба дугаар**: Худаг
**Лаб №** 25/5454

Усны химийн задлан шинжилгээний дүн

| Анион | мг/л | мг/экв | %, мг-экв/л | Катион | мг/л | мг/экв | %, мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|
| $Cl^-$ | 10.64 | 0.30 | 26.27 | $Na^++K^+$ | 11.80 | 0.51 | 45.00 |
| $SO_4^{2-}$ | 4.07 | 0.08 | 7.43 | $NH_4^+$ | 0.20 | 0.01 | 0.97 |
| $NO_3^-$ | 9.63 | 0.16 | 13.62 | $Ca^{2+}$ | 8.02 | 0.40 | 35.08 |
| $NO_2^-$ | 0.03 | 0.00 | 0.06 | $Mg^{2+}$ | 2.43 | 0.20 | 17.54 |
| $CO_3^{2-}$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Fe^{2+}$ | 0.30 | 0.02 | 1.41 |
| $HCO_3^-$ | 36.61 | 0.60 | 52.62 | $Fe^{3+}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 60.98 | 1.14 | 100.00 | Дүн | 22.75 | 1.14 | 100.00 |

| | |
|---|---|
| Анион катионуудын нийлбэр: | 83.73 мг/л |
| $HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: | 65.0 мг/л |
| Хуурай үлдэгдэл: | 70.0 мг/л |
| Ерөнхий хатуулаг: | 0.60 мг-экв/л |
| pH: | 7.74 |
| Исэлдэх чанар: | 0.48 мг/л |

Усны физик шинж. чанар

Шүүгдэсний өнгө: Өнгөгүй
Үнэр: Үгүй
Амт: -
Булингар: Тунгалаг
Тунадас: Үгүй

**Усны давсны химийн найрлагын томьёо** $M\ (70.0\ мг/л) = \frac{HCO-52.62\ Cl-26.27}{Na+K\ 45.00\ Ca-35.08}$

Тайлбар

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 3-р төрлийн , чанарын хувьд нэн цэнгэг буюу ялимгүй эрдэсжилттэй, маш зөөлөн ус байна.

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005)

Лабораторийн эрхлэгч: Л. Цагаандархи /MS.c/

Задлан шинжээч : О.Алтанцэцэг /MS.c/

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 78 ҮИТ0049

## ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

**Дугаар: 25/1681**

**Дээж авсан огноо:** 2025 он 10 сарын 08
**Шинжилгээ хийсэн огноо:** 2025 он 10 сарын 09-10
**Дээж авсан газрын нэр**: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 9-р хороо, Да хүрээ авто худалдааны төв
**Координат: -**
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** "Эко цогц шийдэл"ХХК
**Харилцах утас:** 99074356
**Уст цэгийн төрөл ба дугаар**: Худаг
**Лаб №** 25/8072

Усны химийн задлан шинжилгээний дүн

| Анион | мг/л | мг/экв | %, мг-экв/л | Катион | мг/л | мг/экв | %, мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|
| $Cl^-$ | 10.64 | 0.30 | 21.60 | $Na^+ + K^+$ | 13.00 | 0.57 | 40.76 |
| $SO_4^{2-}$ | 2.59 | 0.05 | 3.89 | $NH_4^+$ | 0.10 | 0.01 | 0.40 |
| $NO_3^-$ | 2.06 | 0.03 | 2.40 | $Ca^{2+}$ | 10.02 | 0.50 | 36.05 |
| $NO_2^-$ | 0.01 | 0.00 | 0.02 | $Mg^{2+}$ | 3.65 | 0.30 | 21.63 |
| $CO_3^{2-}$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Fe^{2+}$ | 0.30 | 0.02 | 1.16 |
| $HCO_3^-$ | 61.02 | 1.00 | 72.10 | $Fe^{3+}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 76.32 | 1.39 | 100.00 | Дүн | 27.07 | 1.39 | 100.00 |

| | |
|---|---|
| Анион катионуудын нийлбэр: | 103.39 мг/л |
| $HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: | 73.0 мг/л |
| Хуурай үлдэгдэл: | 78.0 мг/л |
| Ерөнхий хатуулаг: | 0.80 мг-экв/л |
| pH: | 7.21 |
| Исэлдэх чанар: | 0.64 мг/л |

Усны физик шинж. чанар

Шүүгдэсний өнгө: Өнгөгүй
Үнэр: Үгүй
Амт: -
Булингар: Тунгалаг
Тунадас: Үгүй

**Усны давсны химийн найрлагын томьёо** M ( 78.0 мг/л) = $\frac{HCO-72.10\ Cl-21.60}{Na+K\ 40.76\ \ Ca-36.05\ Mg-21.63}$

Тайлбар

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн , чанарын хувьд нэн цэнгэг буюу ялимгүй эрдэсжилттэй, маш зөөлөн ус байна.

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005)

Лабораторийн эрхлэгч: Л. Цагаандархи /MS.c/

Задлан шинжээч : О.Алтанцэцэг /MS.c/

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ ҮИТ0049

БАТЛАВ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН "ТҮК-4
"ҮЙЛСТ МАНДАЛ" ХХК ЗАХИРАЛ
С. НАМНАНСҮРЭН ............

БАТЛАВ:
"ДА ХҮРЭЭ ТРЕЙД" ХХК
ЗАХИРАЛ Ц. АЛИМАА
............

## ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2024 оны 07-р сарын 03-ны өдөр Улаанбаатар хот

| | |
|---|---|
| Гэрээний дугаар: | 17. |
| Иргэн, ААНБ-ын нэр: | Да хүрээ трейд ХХК. |
| Иргэн, ААНБ-ын регистрийн дугаар: | 2063115 |
| Үйл ажиллагааны чиглэл: | машин худалдаа үйлчилгээ. |
| Иргэн, ААНБ-ын хаяг: | |
| ААНБ-ын холбогдох утас: | 99047707, 88752578 |
| Газарзүйн хязгаарлалт: | Баянзүрх дүүргийн ...9....... –р хороо |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ: | Сард 1500'000. төгрөг |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөл: | Айл өрхийн тоо.......... Сард........ ............₮ \| Сард ..............................₮ 7хоногт 1удаа "даваа гараг" \| Рейсийн тоогоор 1рейс 10. ₮ |
| Төлбөрийн нөхцөл: | Баянзүрх дүүргийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 32 дугаар тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээгээр сар бүрийн 15-25-ны дотор<br>Хог хаягдлын хураамж хүлээн авагчийн нэр: **БЗДНийтлэг Үйлч-ний Газар 4**<br>Харилцах банкны нэр: **ТӨРИЙН БАНК**<br>Дансны дугаар: **109201877280** |
| Гэрээний хугацаа: | 2024 оны ..07...-р сарын 03 –ны өдрөөс<br>2025.. оны ..07...-р сарын 03.-ны өдөр хүртэл |

Нэг талаас Баянзүрх дүүргийн "ТҮК-4 Үйлст мандал ХХК / цаашид "Хог хаягдал тээвэрлэгч" гэх / түүнийг төлөөлж Баянзүрх дүүргийн .........-р хорооны Татвар, тохижилт хариуцсан байцаагч ажилтай ........................... овогтой ............................... нөгөө талаас ............................................ /иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр / төлөөлж / цаашид "Хог хаягдал тээвэрлүүлэгч" гэх / ........................................... ажилтай ....................... овогтой ...................................... нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээ нь Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр /..................../ хороодын буюу зургаадугаар бүсийн нийтийн эзэмшлийн зам талбай, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг цуглуулж, ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэж хариуцсан бүсийг хог хаягдалгүй цэвэр байлгахад оршино.

1.2 Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол улсын "Иргэний хууль", Монгол улсын "Хог хаягдлын тухай" хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

### ХОЁР. ХОГ ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл хуваарийг тогтоож дүүргийн Засаг даргын орлогчоор батлуулж мөрдөнө.

2.2 Батлагдсан хуваарийн дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.

2.3 Хог хаягдлыг зориулалтын битүүмжлэлтэй аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

2.4 Хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нар нь зохих сургалтанд хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлага хангаж ажиллана.

2.5 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үед унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авна.

2.6 Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэхдээ үйлчилгээний хөлс авч үйлчилнэ.

2.7 Хог хаягдлын тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэхүү гэрээний 3.3-3.8 дахь заалтын хэрэгжилтэнд хяналт тавьж, хангалтгүй биелүүлсэн тохиолдолд шаардлага хүргүүлэх.

### ГУРАВ. ХОГ ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Хог тээврийн үйлчилгээний гэрээний төсөлтэй танилцаж, хог хаягдлын тухай хуулийн 10.2.3-д заасны дагуу гэрээ байгуулах.

3.2 Хог хаягдлын тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэ гэрээний 2.2-2.6 дахь заалтын хэрэгжилтэнд хяналт тавьж, хангалтгүй биелүүлсэн тохиолдолд шаардлага тавих эрхтэй.

3.3 Монгол улсын хог хаягдлын тухай хуулийн 15-р зүйлд заасан “Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн” чанарын шаардлага хангасан хогийн савыг байршуулах.

3.4 Хог хаягдлыг зориулалтын хогийн сав болон цэгээс хүлээлгэн өгөх ба хуваарийн дагуу ачих үед саадгүй тээвэрлэх нөхцлийг бүрдүүлнэ. Задгай хог хаягдлыг 80-аас доошгүй литрийн багтаамжтай зориулалтын уутанд хийж савлана. Хөлдүү хогийг захиалагч өөрөө хариуцаж хогийн сав болон орчноос бүрэн суллаж, ачихад бэлдэнэ.

3.5 Хог хаягдлын талаар сургалтанд хамрагдах.

3.6 Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх аваагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ авахыг хориглоно.

3.7 Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон тохиолдолд үйл ажиллагаагаа зогсоох хугацааг урьдчилан мэдэгдэж хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг бичгээр өгнө.

3.8 Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэгч байгууллагад шилжүүлж үйлчилгээний хөлсийг төлнө.

## ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО

4.1 Монгол Улсын “Хог хаягдлын тухай” хуулийн 41 дүгээр зүйлийг үндэслэн хог хаягдал гаргасны төлбөрийг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 32 дугаар тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээгээр ........................................ төгрөгийг сар бүрийн 15-25-ны өдрүүдэд **ТӨРИЙН БАНК** дахь 109201877280 тоот дансанд **ТҮК-4 Үйлст мандал** нэрээр хугацаанд нь бүрэн төлнө.

4.2 Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэх үйлчилгээний хөлс нь хог хаягдлын үйлчилгээний хураамжинд хамаарахгүй. Үйлчилгээний хөлсийг гэрээгээр тохиролцсоны дагуу төлнө.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

5.1 Гэрээ нь 2024 оны ...... сарын ......-ны өдрөөс 202.. оны ....... сарын ........-ны өдөр хүртэл ...... жил ...... сарын хугацаатайгаар байгуулав.

5.2 Гэрээний хугацаа дуусгавар болохоос ажлын 10 хоногийн өмнө аль нэг тал гэрээг цуцлах талаар санал тавиагүй тохиолдолд гэрээг дахин нэг жилээр сунгагдсанд тооцно.

## ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

6.1 Талуудын хагас, бүтэн жилээр гэрээний биелэлтийг дүгнэж, тооцоо нийлсэн акт үйлдэнэ.

6.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол Хог хаягдлын тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

## ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

7.1 Энэхүү гэрээг гүйцэтгэхэд нөлөөлөх давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл /үер ус, газар хөдлөлт, гал түймэр, нийтийг хамарсан үймээн самуун гэх мэт онц байдлын нөхцлүүд/ үүссэн тохиолдолд талууд гэрээний үүргээсээ татгалзах эрхтэй ба гэрээний талууд учирсан хохирлыг төлөхийг шаардах эрхгүй

## НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

8.1 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ЕС. БУСАД

9.1 Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь талуудын эрх тэгш байдал болон гэрээний чөлөөт байдлын зарчим дээр харилцан тохиролцсоны үндсэн дээр хийгдэнэ.

9.3 Энэхүү гэрээ нь Монгол хэлээр 2 ижил хувь хийгдэх бөгөөд нэг хувийг иргэн аж ахуйн нэгж, байгууллага нөгөө хувийг Баянзүрх дүүргийн “Нийтлэг Үйлчилгээний Газар Тав” ОНӨААТҮГ тус тус авна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| Тээвэрлэгчийг төлөөлж:<br>БЗД-ийн ,ТҮК 4 –ийн менежер<br>Изргүй овогтой Дулам<br>/…………………<br>Гарын үсэг: /...Дулам<br>Утас: 99847661 | Тээвэрлүүлэгчийг төлөөлж<br>ХД-ний тэрга<br>Гарын үсэг: [signature] /, О. Алтанзаяа<br>Утас: 88752578 |

## НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ БАТАЛГААЖУУЛСАН:

| | |
|---|---|
| Тээвэрлэгчийг төлөөлж:<br>БЗД-ийн ,ТҮК 4-ийн менежер<br>Изргүй овогтой Дулам<br>/…………………<br>Гарын үсэг: /..Дулам/<br>Утас: 99847661 | Тээвэрлүүлэгчийг төлөөлж<br>.............................................<br>Гарын үсэг: /………/<br>Утас: ………………… |

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 54-Р БҮС ХАРИУЦСАН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОМПАНИ “ҮЙЛСТ МАНДАЛ” ХХК**

# ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

**№………….**

Улаанбаатар хот 2024

БАТЛАВ

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ТҮК-4
"ҮЙЛСТ МАНДАЛ" ХХК ЗАХИРАЛ
С. НАМНАНСҮРЭН /......................./

БАТЛАВ

"Да хүрээ трейд" ХХК
Захирал
......................................

Улаанбаатар хот

**ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

2024 оны 7 -р сарын 3 -ны өдөр

| | | | |
|---|---|---|---|
| Гэрээний дугаар: | 17. | | |
| Иргэн, ААНБ-ын нэр: | Да хүрээ трейд ХХК. | | |
| Иргэн, ААНБ-ын регистрийн дугаар: | 2063115 | | |
| Үйл ажиллагааны чиглэл: | машин худалдаа, үйлчилгээ | | |
| Иргэн, ААНБ-ын хаяг: | | | |
| ААНБ-ын холбогдох утас: | 99047707, 88752578 | | |
| Газарзүйн хязгаарлалт: | Баянзүрх дүүргийн ....9...... –р хороо | | |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ: | Сард 1500000 төгрөг | | |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөл: | Айл өрхийн тоо.......... Сард............... ......₮ | Сард ...................... ...₮ 7 хоногт 1 удаа "давхар гаргат" | Рейсийн тоогоор 1рейс ........10.........₮ |
| Төлбөрийн нөхцөл: | Баянзүрх дүүргийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 32 дугаар тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээгээр сар бүрийн 15-25-ны дотор<br>Хог хаягдлын хураамж хүлээн авагчийн нэр: **БЗД Тохижилт үйлчилгээний компани 4**<br>Харилцах банкны нэр: **ТӨРИЙН БАНК**<br>Дансны дугаар: **109201877280** | | |
| Гэрээний хугацаа: | 2024 оны .07..-р сарын .03. –ны өдрөөс<br>2025.. оны ..07..-р сарын ..03..-ны өдөр хүртэл | | |



Энэхүү гэрээ нь Монгол улсын "Хог хаягдлын тухай хууль", Сангийн сайд, БОАЖ-ын сайдын хамтарсан 2018 оны 192,А/243 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал", Баянзүрх дүүргийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 32-р тогтоолоор баталсан "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн баримтална.

Нэг талаас Баянзүрх дүүргийн "Нийтлэг Үйлчилгээний Газар 4" ОНӨААТҮГ / цаашид "Хог хаягдал тээвэрлэгч" гэх / түүнийг төлөөлж Баянзүрх дүүргийн .........-р хорооны Татвар, тохижилт хариуцсан байцаагч ажилтай .......................... овогтой ............................ нөгөө талаас ...................................... /иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр / төлөөлж / цаашид "Хог хаягдал тээвэрлүүлэгч" гэх / ........................................ ажилтай ...................... овогтой .................................... нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээ нь Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр /..... / хороодын буюу ......... бүсийн нийтийн эзэмшлийн зам талбай, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, Баянзүрх дүүргийн ТҮК-4 хог хаягдлыг цуглуулж, ачиж тээвэрлэн, төвлөрсөн хогийн цэгт хүргэж хариуцсан бүсийг хог хаягдалгүй цэвэр байлгах, Дүүргийн Татварын хэлтэс хог хаягдлын төлбөрийг цаг тухайд нь төрийн сангийн дансанд төвлөрүүлэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол улсын "Иргэний хууль", Монгол улсын "Хог хаягдлын тухай", "Татварын ерөнхий" хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

## ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. "А" талын эрх:

2.1.1 Хог тээврийн үйлчилгээний гэрээний төсөлтэй танилцаж, Монгол улсын "Хог хаягдлын тухай" хуулийн 10.2.3-д заасны дагуу Энгийн болон Ахуйн хог хаягдлыг тээвэрлүүлэх гэрээ байгуулах.

2.1.2.Хог хаягдлын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэ гэрээний 2.4.2-2.4.5 дахь заалтын хэрэгжилтэнд хяналт тавьж, хангалтгүй биелүүлсэн тохиолдолд шаардлага тавих эрхтэй.

2.2. "А" талын үүрэг:

2.2.1.Монгол Улсын Хог хаягдлын хуулийн 15-р зүйлд заасан "Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тундасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн" чанарын шаардлага хангасан, ачаалалдаа тохирсон хогийн савыг байршуулах.

2.2.2 Хог хаягдлыг зориулалтын хогийн сав болон цэгээс хүлээлгэн өгөх ба хуваарийн дагуу ачих үед саадгүй тээвэрлэх нөхцлийг бүрдүүлнэ.

2.2.3.Задгай хог хаягдлыг 25-аас доошгүй литрийн багтаамжтай зориулалтын уутанд хийж, савлана.

2.2.4.Хөлдүү болон халуун чанарын хог хаягдлыг захиалагч өөрөө хариуцаж аюулгүй болгож хогийн сав болон орчноос бүрэн суллаж, ачихад бэлтгэнэ.

2.2.5.Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд тээвэрлэгч байгууллагад хүсэлт гаргаж, хуулийн дагуу тусдаа гэрээ байгуулж, тээвэрлэгчид хог хаягдлын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлсний үндсэн дээр тухайн хог хаягдлыг

## “ДА ХҮРЭЭ ТРЕЙД” ХХК-НИЙ ГАЛ УНТРААХ БАГАЖ ХЭРЭГСЛЭЛД ҮЗЛЭГ ХИЙСЭН БҮРТГЭЛ

2025.08.27 Да хүрээ

| № | ГК-ийн байршил | Хариуцсан эзэн | Галын хор | Хүрз | Цоож | Татуурга дэгээ | Усны хувин | Элстэй сав | Галын цохиур | Хөрөө | Лоом | Сүх | Жоотуу | Бортого | Чирэгч хатуу холбоо | Гидрант | ГК хаяг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1-р постны харъяа объектуудын ГК** | | | | | | | | | | | | | | | | | |
| 1. | 1-р постны доор | Э.Ахлах | 3 | 7 | 1 | 2 | 5 | 1 | 2 | 1 | | 1 | 2 | | 2 | | 2 |
| 2. | ХҮ-ний 1-р байрны урд | Э.Ахлах | 8 | | 2 | | | 1 | | | | | | | | | |
| 3. | ХҮ-ний 1-р байр дотор | Э.Ахлах | 5 | | | | | | | | | | | | | | |
| 4. | ХҮ-ний 2-р байр | Э.Ахлах | 4 | | | | | | | | | | | | | | |
| 5. | Уурын зуух №1 | Э.Ахлах | | | | | | | | | | | | | | | |
| 6. | Уурын зуух №2 | Э.Ахлах | | | | | | | | | | | | | | | |
| 7. | Алтан жолоо япон сэлбэг | Э.Ахлах | 2 | 2 | 1 | | 1 | 1 | 1 | | 1 | | 1 | 2 | | | |
| 8. | НБЗГ-I | Э.Ахлах | 1 | | | | | | | | | | | | | | |
| 9. | | | | | | | | | | | | | | | | | |
| **Нийт** | | | **23** | **9** | **4** | **2** | **6** | **3** | **3** | **1** | **1** | **1** | **3** | **2** | **2** | | **2** |
| **2-р постны харъяа объектуудын ГК** | | | | | | | | | | | | | | | | | |
| 1. | Акк-ын эгнээний буланд | Хамгаалагч | 1 | 2 | 1 | | 1 | 1 | 1 | | | | 1 | 2 | | | |
| 2. | Байцаагчийн байр №6 | Байцаагч | 1 | | | | | | | | | | | | | | |
| 3. | Постон дотор/гадна/ | Хамгаалагч | 1 | 2 | | | 3 | 1 | 1 | | | | 1 | | | | |
| 4. | | | | | | | | | | | | | | | | | |
| **Нийт** | | | **3** | **4** | **1** | | **4** | **2** | **2** | | | | **2** | **2** | | | |
| **3-р постны харъяа объектуудын ГК** | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | 3-р постны доор | Хамгаалагч | 4 | 3 | 1 | 2 | 3 | | 2 | 1 | 1 | 1 | 1 | | 1 | | **1** |
| 2 | Байцаагчын байр | Хамгаалагч | 1 | | | | | | | | | | | | | | |
| 3 | Өлзийт баруун | Хамгаалагч | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Өлзийт зүүн | Хамгаалагч | 2 | 2 | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | | 1 | 1 | 2 | | | **1** |
| 5 | Өлзийт урд | Хамгаалагч | 1 | 2 | 1 | 1 | 2 | 1 | | | | | | 2 | | | **1** |
| 6 | | Хамгаалагч | | | | | | | | | | | | | | | |
| **Нийт** | | | **8** | **7** | **3** | **4** | **7** | **2** | **3** | **2** | **1** | **2** | **2** | **4** | **1** | | **3** |
| **№** | **ГК-ийн байршил** | **Хариуцсан эзэн** | **Галын хор** | **Хүрз** | **Цоож** | **Татуурга дэгээ** | **Усны хувин** | **Элсний сав** | **Галын цохиур** | **Хөрөө** | **Лоом** | **Сүх** | **Жоотуу** | **Бортого** | **Чирэгч хатуу** | **Гидрант** | **Тросс** |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **4-р постны харъяа объектуудын ГК** | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1. | 2-р хогийн цэгийн дэргэд | | Хамгаалагч | 2 | 2 | 1 | 1 | 2 | 1 | 2 | 1 | | 1 | 1 | 1 | | | |
| 2. | ХҮ-ний 3-р байр | | Хамгаалагч | 7 | | | | | | | | | | | | | | |
| 3. | Авто Центр | | Хамгаалагч | 13 | | | | | | | | | | | | | 4 | |
| 4. | Наран ц/г-ын ард | | Хамгаалагч | 1 | 2 | 1 | | | | 1 | 1 | | | 1 | | | | |
| 5. | Байцаагчийн байр №2 | | Байцаагч | 1 | | | | | | | | | | | | | | |
| 6. | Байцаагчийн байр №3 | | Байцаагч | 1 | | | | | | | | | | | | | | |
| 7. | НБЗГ-II | | Үйлчлэгч | 1 | | | | | | | | | | | | | | |
| 8. | 1-р хогийн цэг | | Хамгаалагч | 3 | 1 | 2 | | 2 | 1 | 1 | 1 | 1 | | 1 | | | | |
| **Нийт** | | | | **29** | **5** | **2** | **1** | **2** | **1** | **1** | **1** | **1** | | **1** | **1** | | **4** | |
| **5-р постны харъяа объектуудын ГК** | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1. | 5-р постны доор | | Хамгаалагч | 2 | 5 | 1 | 1 | 4 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | | | | |
| 2. | 5-р постны гадна | | Хамгаалагч | 2 | 2 | 1 | | 2 | | 1 | | | | 1 | | | | |
| 3. | Авто салон | Галын тэрэг-1 | Хамгаалагч | | | | | | | | | | | | | | | |
| | | ГК | Хамгаалагч | | | | | | | | | | | | | | | |
| | | Дотор | Хамгаалагч | 26 | | | | | 12 | | | | | | | | | |
| 4. | Автосалоны гадна | | Хамгаалагч | | | | | | | | | | | | | | | |
| 5. | Амтлаг зоогийн ард | | | | 2 | | | 1 | | | | | | 1 | 1 | | | |
| **Нийт** | | | | **30** | **9** | **2** | **1** | **7** | **13** | **3** | **1** | **1** | **1** | **3** | **1** | | | |
| **6-р постны харъяа объектуудын ГК** | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | 6-р постны доор | | Хамгаалагч | 3 | 3 | 1 | 1 | 4 | 1 | 3 | 1 | 1 | 1 | 1 | | | | |
| 2 | Оношлогооны хашаанд | | Хамгаалагч | 2 | 2 | 1 | 2 | 2 | 1 | 1 | 1 | | | 1 | | | | |
| 3 | Дэлгүүр №65-ийн урд | | Хамгаалагч | 2 | 1 | 1 | | 2 | 1 | 3 | 1 | 1 | | 1 | 2 | | | |
| 4 | Дэлгүүр №57-ийн урд | | Хамгаалагч | 2 | 1 | 1 | | | | | | | | 1 | | | | |
| 5 | Кон №21 ийн хажууд | | Хамгаалагч | 2 | 2 | 1 | | 1 | | 1 | | | | 1 | 1 | | | |
| 6 | Дэлгүүр №33-ийн урд | | Хамгаалагч | 1 | 2 | 1 | | 1 | 1 | 1 | | | | 1 | 2 | | | |
| 7 | 3-р хогийн цэг | | Хамгаалагч | 4 | 2 | 1 | 1 | 3 | 1 | | | | 1 | 1 | | | | |
| 8 | Завхан голын эгнээ | | Хамгаалагч | 1 | 2 | 1 | | 2 | | 1 | | | | 1 | | | | |
| 9 | Япон сэлбэгийн 6-р эгнээ | | Хамгаалагч | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 1 | | 1 | | 1 | | | | |
| 10 | | | | **18** | **17** | **9** | **5** | **16** | **6** | **11** | **3** | **3** | **2** | **9** | **5** | | | |
| **Нийт** | | | | **111** | **51** | **21** | **13** | **42** | **27** | **23** | **8** | **7** | **5** | **20** | **15** | **3** | **4** | **0** |

| № | Чиглэл | Байршил | Галын хор | Хүрз | Цоож | Татуурга дэгээ | Усны хувин | Элсний сав | Галын цохиур | Хөрөө | Лоом | Сүх | Жоотуу | Бортого | Чирэгч хатуу холбоо | Гидрант | Тросс |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Нийт | 34 | 101 | 40 | 22 | 14 | 33 | 31 | 29 | 12 | 12 | 9 | 16 | 17 | 4 | 4 | 1 |
| 2. | Компаний | 22 | 80 | 32 | 10 | 12 | 17 | 30 | 24 | 9 | 10 | 7 | 10 | 16 | 4 | 4 | 1 |
| 3. | Гадны | 12 | 21 | 8 | 12 | 2 | 16 | 1 | 5 | 3 | 2 | 2 | 6 | 1 | - | - | - |

**ГАДНЫ НЭГЖИЙН ГК-НЫ ЖАГСААЛТ**

| № | ГК-ийн байршил | Хариуцсан эзэн | Галын хор | Хүрз | Цоож | Татуурга дэгээ | Усны хувин | Элсний сав | Галын цохиур | Хөрөө | Лоом | Сүх | Жоотуу | Бортого | Чирэгч хатуу холбоо | Гидрант | Тросс |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1-р постны харъяа объектуудын ГК** | | | | | | | | | | | | | | | | | |
| 1. | Алтан жолоо япон сэлбэг | Хадхүү | 1 | 1 | 1 | | 2 | | | | | | | | | | |
| **2-р постны харъяа объектуудын ГК** | | | | | | | | | | | | | | | | | |
| 2. | Акк-ын эгнээний буланд | | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | | 1 | | 1 | | | | **1** |
| **3-р постны харъяа объектуудын ГК** | | | | | | | | | | | | | | | | | |
| 3. | Дугуй, тосны хэсэг | | 3 | | 1 | | | | | | | | | | | | |
| 4. | Өлзийт ко -20 ийн хажууд | Оюунболд | 1 | 1 | 1 | 1 | 1 | | **2** | | 1 | | | | | | |
| 5. | Сайхан зоог ц/г-ын урд | Баттулга | 4 | | 1 | | 1 | 1 | 1 | | | | 1 | 1 | | | |
| 6. | Акк-ын эгнээний буланд | | 1 | 1 | 1 | | 2 | | | | | | | | | | |
| 7. | Зав/гол пав 22 ийн хойно | Баярмаа | 2 | 1 | 1 | | 1 | | **1** | | | | 1 | | | | |
| **4-р постны харъяа объектуудын ГК** | | | | | | | | | | | | | | | | | |
| 8. | Наран ц/г-ын ард | Уртнасан | 1 | 1 | 1 | | 2 | | | 1 | | | 1 | | | | |
| **6-р постны харъяа объектуудын ГК** | | | | | | | | | | | | | | | | | |
| 9. | Дэлгүүр №66-ийн урд | Цэрэндолгор | 2 | | 1 | | 1 | | | | | | 1 | | | | |
| 10 | Дэлгүүр №89-ийн урд | Энхбаатар | 1 | 1 | 1 | | | | | | 1 | **1** | 1 | | | | |
| 11 | Кон №187 ийн хажууд | Мөнхтөр | 2 | 1 | 1 | | 2 | | | 1 | | | | | | | |
| 12 | Дэлгүүр №85-ийн урд | Ганцэвэлмаа | 2 | 1 | 1 | 1 | 2 | | 1 | 1 | | 1 | 1 | | | | |
| | | Нийт | 21 | 8 | 12 | 2 | 16 | 1 | 5 | 3 | 2 | 2 | 6 | 1 | | | |

**Дүгнэлт:** Худалдааны төвийн хэмжээнд нийт 34 байршилд /өөрийн 22, гадны 12/ ГК байрлаж байна. Нийт ГК-ний багаж хэрэгсэл, сарааны ашиглалтын шалгалтыг хийсэн. Компаний ГК-ний багаж хэрэгсэл, материал, сарааны ашиглалт хэвийн.

БАТЛАВ. "ГОЛДЕН ЭКО" ХХК
Захирал.....
/Н.ДАШБАЯР/

Батлав. Да Хурээ Трейд ХХК
Захирал.....

# БОХИР УС ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

20.22. он .07. сар .01. өдөр Дугаар 22/07 Улаанбаатар хот

## Бохир ус тээвэрлэлтийн гэрээг

Нэг талаас Монгол улс, БЗДүүрэг 4-р хороо 15-р хороолол 53-12 тоот хаягт оршин суух **"Голден эко" ХХК** түүнийг төлөөлж **захирал** ажилтай **Норолхоожав овогтой Дашбаяр** /цаашид гүйцэтгэгч гэх/ /УБД: 9011450124 РД: 5782473/

Нөгөө талаас Да Хурээ Трейд ХХК түүнийг төлөөлж **захирал** ажилтай И.Аминаа...../цаашид захиалагч гэх/ нар Монгол Улсын иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомжуудыг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## Нэг.Захиалагчийн эрх, үүрэг

1.1 Захиалагч тал нь бохир усыг татуулах, тээвэрлүүлэхдээ гүйцэтгэгч талд утсаар захиалга өгч замын хуудас бөглүүлж тухайн гүйцэтгэлийг баталгаажуулна.

1.2 Бохир усыг соруулахдаа ажил гүйцэтгэх автомашин багтахаар зам талбайг чөлөөтэй байлгах.

1.3 Захиалагч гэрээний дагуу ажлын хөлсөө хугацаанд нь төлөх, хэрэв хугацаа хожимдсон тохиолдолд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0,5 хувийн алданги тооцож авна.

1.4 Захиалагч тал нь ажлын цагийг урьдчилан зааж захиалга өгөх ба урьдчилсан захиалгыг заавал 1 өдрийн өмнө мэдэгдэж захиалгыг 99992833 дугаарын утсаар өгнө.

## Хоёр. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг

2.1 Гүйцэтгэгч тал нь бохир усыг татан зайлуулахдаа 7 тн тусгай зориулалтын Мицубиши фусо маркийн 1647 дна улсын дугаартай авто машин болон компаний бусад тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

2.2 Гүйцэтгэгч нь Захиалагчийн мэдэгдсэн хугацаанд ажлыг очиж гүйцэтгэнэ.

2.3 Гүйцэтгэгч нь давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас үүссэн аливаа асуудлыг захиалагчийн өмнө хариуцахгүй болно.

## Гурав. Төлбөр тооцоо

3.1 Бохир ус тээвэрлэлтийн ажлын нэг удаагийн ажлын хөлс нь (60,000) /жаран мянган/ төгрөг байна.

3.2 Захиалагч тал нь Гүйцэтгэгч талтай тохирсон хугацаанд ажлын гүйцэтгэлээр тооцож төлбөрийг НӨАТ-тэй, НӨАТ-гүй /зур/ хийнэ. Захиалагч тал нь тохиролцсон хугацаандаа төлбөрийг хийгээгүй тохиолдолд энэхүү гэрээний 1.3-т заасны дагуу алданги тооцож олгоно.

## Дөрөв. Талуудын хариуцлага

4.1 Гүйцэтгэгч тал нь автомашиныг урьдчилан үзлэг, оношлогоонд хамруулж ажилд байнгын бэлэн байлгах ба автомашин гэрээт ажлын явцад саатах тохиолдолд оронд нь өөр тээврийн хэрэгслээр үйлчилнэ.

4.2 Хоёр тал ажлыг цаг хугацаанд үр дүнтэй явуулахыг аль алин хичээх ба гэрээт ажлын явцад гарсан ямар нэгэн бэрхшээлтэй асуудлыг хамтын замаар шийдвэрлэх болно.

4.3 Зайлшгүй бөгөөд баримтаар нотлогдсон зөрчил маргааныг хамтын хүчээр шийдвэрлэж чадаагүй тохиолдолд зохих хууль журмын дагуу хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

## Тав. Нэмэлт нөхцөл

5.1 Төлбөрийг харилцан тохиролцож бэлнээр буюу гүйцэтгэгч компаний ....ХАС.... **банкин** дахь ....5001048944.... тоот дансанд ажлын гүйцэтгэлээр тооцож шилжүүлнэ.

5.2 Энэхүү гэрээ нь 20.22. оны .07.-р сарын .01..-наас эхлэн 20.24. оны .07.-р сарын .01.-ны өдөр хүртэл 2...... /хоёр/......./ жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх болно.

5.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах буюу гэрээ цуцлах тохиолдолд 45 хоногийн өмнө гэрээний аль нэг талд албан тоот бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдээгүй тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр гэж үзнэ.

5.4 Гэрээ цуцлах тохиолдолд өмнөх он болон бусад ямар нэгэн төлбөр тооцоог бүрэн барагдуулсан байх болно.

5.5 Шаардлагатай тохиолдолд гарсан шугам бөглөрөх болон бусад ажлуудыг хийх бол харилцан тохиролцож хийнэ.

5.6 Тус компани нь Хот Суурин Усан Хангамж Ариутгах Татуургын зөвлөлөөс олгогдсон 00430 тоот тусгай зөвшөөрөлтэй болно.

5.7 УСУГ-ын бохир ус татан зайлуулах №34006600 тоот гэрээтэй болно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**Гүйцэтгэгчийг төлөөлж:**
/Н.Дашбаяр/
......................................
Хаяг: БЗД-ийн 4-р хороо
15-р хороолол 53-12 тоот
Утас: 99992833

**Захиалагчийг төлөөлж:**
/ Ц.Анхбаяр /
......................................
Хаяг: ....БЗ дүүрэг....
17-р хороо ... Хурд групп ХХК
Утас:....96880399....

12.3

БАТЛАВ
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН
ДАРГА Ц.ТӨРХҮҮ

**ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫГ "ЦЭВЭР УСААР ХАНГАХ, ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ" АЖ АХУЙН ГЭРЭЭ**

20 21 оны 6 сарын 16 өдөр Хэрэглэгчийн дугаар 24055200

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Нэг талаас УСУГ түүнийг төлөөлж А/41 дугаар тушаалыг үндэслэн гэрээний инженер албан тушаалтай П.Бат-Оюун цаашид *"хангагч"* гэх, нөгөө төлөөс Да хүрээ трейд ХХК-ийн захирал албан тушаалтай У.Лхамаа *"хэрэглэгч"* гэх нар нь "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 13 дугаар зүйл болон бусад холбогдох хуулийг удирдлага болгон 20 21 оны 6 –р сарын 16–ны өдрөөс эхлэн дор дурьдсан нөхцлийг биелүүлж ажиллахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулж байна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааг зохицуулах дүрэм нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

## ХОЁР. НИЙЛҮҮЛЭХ ЦЭВЭР УС БОЛОН ТАТАН ЗАЙЛУУЛАХ БОХИР УСНЫ ХЭМЖЭЭ, ЧАНАР, НАЙРЛАГА, ТӨЛБӨР, ТООЦОО ХИЙХ

2.1 Хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр ус болон хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан усны тоолуураар хэмжих ба хэрэглээг тоолуурын заалтыг үндэслэн тооцно. Тоолуурын заалтаар гарсан хэрэглэсэн цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон бусад түүнтэй холбогдох төлбөрийг "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл"-ийн баталсан усны үйлчилгээний тарифыг мөрдлөг болгоно.

2.2 Хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг тухайн хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээтэй адилаар тооцно.

2.3 Хэрэглэгчийн хэрэглээнээс гарч байгаа бохир усны найрлага нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн 50 дугаар тогтоолоор батлагдсан MNS 6561:2015 "Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны найрлага"-ын зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд Монгол улсын Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын дагуу ус бохирдуулсны төлбөрийн хэмжээгээр нэмэлт төлбөр төлнө.

2.4 ....1..... циклд хамрагдаж байгаа хэрэглэгчийн усны тоолуурын заалтыг сар бүрийн ..1..-ээс ..7..-ны хооронд авах бөгөөд хангагч, хэрэглэгчийн төлөөлөгч хамтран хяналтын картанд харилцан гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.

2.5 Хангагч нь ......1..... циклийн хэрэглэгчийн усны төлбөрийн нэхэмжлэх болон тооцооны хуудсыг сар бүрийн ..8..-ны өдөр www.eus.mn сайтад байршуулж, төлбөрийн нэхэмжлэл гарсан тухай мессежийг хэрэглэгчийн гэрээнд тэмдэглэгдсэн утасны дугаарт илгээнэ.

2.6 Хангагч нь сар бүрийн ..14..-ээс..15..-ний дотор хэрэглэгчийн төлбөр төлөх эцсийн хугацааг мессежээр сануулна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13.2 дахь заалтыг үндэслэн хэрэглэгчидтэй байгуулах энэхүү гэрээний маягтыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй зөвшилцсөн болно.

6.1.6 Тухайн хэрэглэгчийн эзэмшил дээрх ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн бүрэн бус байдлын талаар илэрсэн зөрчлийг арилгах шаардлагыг хүлээн авч биелүүлээгүй тохиолдолд.

6.2 Хангагч нь “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн 16.1.1, 16.1.2, 16.1.3-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрэглэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагаанд хязгаарлалт хийж болно.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ГЭРЭЭ ДҮГНЭХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ЦУЦЛАХ НӨХЦӨЛ

7.1 Тус гэрээ байгуулсан өдрөөс эхлэн аль нэг талаас гэрээг цуцлах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө. /Энэхүү гэрээ нь анх .... оны ... сарын ... өдөр байгуулсан гэрээний үргэлжлэл болно./

7.2 Хангагч, хэрэглэгч нь жилд нэг удаа гэрээг дүгнэж, дараа жилийн цэвэр, бохир усны гэрээнд тодотгол хийнэ. /Энэхүү заалт нь гэрээ байгуулсан хугацаа болон хэрэглэгчийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарна./

7.3 Хэрэглэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ 3 ба түүнээс дээш удаа зөрчсөн тохиолдолд цаашид гэрээг сунгах эсэх асуудлыг хангагчийн техникийн зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

7.4 Хэрэглэгч нь аж ахуйн гэрээний 4.13 заалтыг хангаж ажиллаагүй нөхцөлд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр гэрээ цуцлах арга хэмжээ авна.

7.5 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргасан тал нь 14 хоногийн өмнө мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. /Нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ./

7.6 Хэрэглэгч нь цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ 3 удаа биелүүлээгүй тохиолдолд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр гэрээг цуцлах арга хэмжээ авна.

7.7 Хангагч, хэрэглэгч нь аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба шийдэлд хүрээгүй тохиолдолд шүүх, хууль хяналтын байгууллагаар маргааныг шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| Хангагчийн талаас: | Хэрэглэгчийн талаас: |
| --- | --- |
| ХҮА-ны дарга......................./ У. Баасанжав ...../ | Захирал Б. Алимаа ...................../ И. Алимаа ........./ |
| (тамга, гарын үсэг) (нэр) | (тамга, гарын үсэг) (нэр) |
| Гэрээний инженер................/ П. Баярмаа | менетер М. Нямдорж ........................ |

БАТЛАВ

"ЭС И ЭС ЭЛ СМАРТ СОЛЮШН" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
______________/Ч. АГИЙМАА/

"Да хүрээ трейд" ХХК-н
Захирал
/Д. Амарзул/

# ХУВАНЦАР САВ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 8 сарын 1 өдөр SESL-24/.... Улаанбаатар хот

Энэхүү хуванцар сав нийлүүлэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас, "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК (РД:6990916) /цаашид "Худалдан авагч" гэх/, түүнийг төлөөлж Н. Ганчимэг .........................................

Нөгөө талаас, "Да хүрээ трейд" ХХК "(РД: 2063115) /цаашид "Нийлүүлэгч" гэх/, түүнийг төлөөлж Б. Одонтуяа /хамтад нь "Талууд" гэх/ нар харилцан тохиролцож байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээний зорилго нь нийлүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан, худалдан авагчийн шаардлагыг хангахуйц PET1 тэмдэглэгээ бүхий ундаа, усны хуванцар сав, бүх төрлийн лаазыг хүлээлгэж өгөх, худалдан авагч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх болон бусад харилцааг зохицуулахад оршино.

## ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО, ХУГАЦАА

2.1 1кг хуванцар савны үнэ 400 (дөрвөн зуу), цэг дээр хүлээн авах үнэ 600 (зургаан зуу) төгрөг тус тус байна.

2.2 Нийлүүлэгч төлбөр төлөгдсөнөөс хойш ажлын 3 хоногийн дотор и-баримтыг шивнэ.

2.3 ***Төлбөр төлөх нөхцөл:*** Хуванцар савыг хүлээлгэж өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.

2.4 ***Төлбөр төлөх данс:*** Нийлүүлэгчийн .............................. тоот ............................ дансны нэртэй ".................................." банкны дансаар төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.

2.5 ***Гэрээний хугацаа:*** Энэхүү гэрээ нь баталгаажсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

2.6 Гэрээний хугацаа дуусах үед талууд ямар нэгэн санал гаргаагүй бол гэрээ дахин 1 жилээр сунгагдана.

2.7 Гэрээний төлбөрийг нэмэх, хасах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдэх бөгөөд зөвхөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинэ төлбөрийн нөхцөл болон дүн баталгаажна.

2.8 Нийлүүлэгчийн хүлээлгэж өгсөн хуванцар савнууд дунд өөр төрлийн хуванцар сав болон хэт бохирдсон хуванцар сав нь 2кг–аас хэтэрсэн тохиолдолд энэ талаар мэдээллийг Худалдан авагч нь Нийлүүлэгчид мэдэгдэж нийт хэмжээгээр хорогдолд тооцож төлбөрийг төлнө.

## ГУРАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

3.1 **Нийлүүлэгчийн хүлээх үүрэг**

БАТЛАВ:
"ДА ХҮРЭЭ ТРЕЙД" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
.............Ц.АЛИМАА

БАТЛАВ:
.................................
АЖИЛТАН
.............Л.ДАВААНЯМ

## ХАЯГДАЛ ЦААСАН ХАЙРЦАГ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

202 4... оны 04.... сарын 17... өдөр

Улаанбаатар хот

Энэхүү хаягдал цаасан хайрцаг нийлүүлэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас "Да хүрээ трейд" ХХК (РД:2063115) /цаашид нийлүүлэгч гэх/, түүнийг төлөөлж ДХШ, ХАБЭА-н менежер ......................................

Нөгөө талаас ................................./РД ОР: 7305 2016 /цаашид "худалдан авагч гэх"/, түүнийг төлөөлж иргэн Л.Даваанями......................... /хамтад нь "Талууд" гэх/ нар харилцан тохиролцож байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээний зорилго нь нийлүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан хаягдал цаасан хайрцагнуудыг худалдан авагчид хүлээлгэн өгөх, Худалдан авагч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх болон бусад харилцааг зохицуулахад оршино.

## ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО, ХУГАЦАА

2.1 Нэг тонн хаягдал цаасан хайрцагны үнэ 40,000 төгрөг /дөчин мянга/ төгрөг байна. /Дуудлагаар/

2.2 Нийлүүлэгч тал худалдан авагчид дуудлага өгсөн тохиолдолд 1-2 хоногийн дотор ирж хаягдал цаасыг ачиж авна.

2.3 *Төлбөр төлөх нөхцөл:* Хаягдал цаасан хайрцагийг ачиж авсан өдрөө бэлнээр кассанд тушаана.

2.4 *Төлбөр төлөх данс:* Нийлүүлэгчийн 5019657777 тоот ***Да хүрээ трейд*** дансны нэртэй "Хаан" банкны дансаар төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.

2.5 *Гэрээний хугацаа:* Энэхүү гэрээ баталгаажсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

2.6 Гэрээний хугацаа дуусах үед талууд ямар нэгэн санал гаргаагүй бол гэрээ дахин 1 жилээр сунгагдана.

2.7 Гэрээний төлбөрийг нэмэх, хасах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдэх бөгөөд зөвхөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинэ төлбөрийн нөхцөл болон дүн баталгаажна.

## ГУРАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

***3.1 Нийлүүлэгчийн хүлээх үүрэг***

3.1.1 Нийлүүлэгч нь бүх төрлийн хаягдал цаасан хайрцаг хүлээлгэн өгнө.

3.1.2 Нийлүүлэгч цаасан хайрцагнуудыг хогийн цэгүүдээс цуглуулж, нэг байрлалд төвлөрүүлэн хураах үүрэгтэй

Батлав. Захиалагч: "Да хурэ трейд" ХХК
Дарга /Захирал/
................................................./

Батлав. Гүйцэтгэгч:
"Баатарван Жаргалант" ХХК
Захирал
/................................................/ Б.Алтансүх /

# АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙТГЭЛ, ШАВЬЖ МЭРЭГЧ УСТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот №....... Огноо: 2021-11-2

Нэг талаас "Да хурэ" трейд ........... (цаашид "Захиалагч" гэнэ), нөгөө талаас "Баатарван Жаргалант ХХК (рег:5291283), тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар АУХ-19/22/3764 (цаашид "Гүйцэтгэгч", хамтад нь "Талууд" гэнэ) нар харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

## 1. Ерөнхий зүйл

1.1. Халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, хортон шавьж, мэрэгчийн тархалтыг багасгаж, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор энэхүү гэрээг байгуулав.

1.2. Монгол Улсын Ариун цэврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн заалтууд, 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт, 18 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, болон бусад хууль тогтоомжийн дагуу ариутгал халдваргүйтгэл, шавьж, мэрэгч устгалын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

## 2. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Энэхүү гэрээ нь 2021.... оны ...11..... сарын...24... өдрөөс эхлэн 2022.... оны ...11.... сарын 24... өдөр хүртэл хүчинтэй. Гэрээний хугацаа дууссан боловч талууд гэрээг дуусгавар болгох тухай нөгөө талдаа албан ёсоор мэдэгдээгүй бол гэрээг цаашид ижил хугацаа, нөхцөлтэйгээр сунгагдсанд тооцно.

2.2. **Ариутгал, халдваргүйтгэлийн** үйлчилгээг объектийн харилцан тохиролцсон хамрагдах нийт 2940...... м2 талбайд жилд ...4... удаа хийж гүйцэтгэнэ.

2.3. **Шавьж устгалын** үйлчилгээг нийт...2940.....м2 талбайд жилд ...4...... удаа хийж гүйцэтгэнэ.

2.4. **Мэрэгч устгалын** үйлчилгээг нийт...2940.....м2 талбайд жилд ...4...... удаа хийж гүйцэтгэнэ.

## 3. ГЭРЭЭНИЙ ҮНЭ

3.1. **Ариутгал, Халдваргүйтгэл** 1м2.........400.........төгрөгөөр, /халдваргүйтгэл хийх бодисын нэр төрлөөс хамаарна./ Нийт: 2940...... м2 талбайг нийт ......1,176,000.................... төгрөгөөр гүйцэтгэнэ.

3.2. **Шавьжгүйтгэл** 1м2 .........500......... төгрөгөөр/ Нийт .......2940.......... м2 талбайг нийт ..1,470,000................ төгрөгөөр гүйцэтгэнэ.

3.3. **Мэрэгчгүйтгэл** 1м2 .........500......... төгрөгөөр/ Нийт .......2940.......... м2 талбайг нийт ..1,470,000................ төгрөгөөр гүйцэтгэнэ.

3.4. Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад ажлын хэмжээ, агуулга өөрчлөгдсөн тохиолдолд хоёр тал тохиролцон зохих журмын дагуу тооцож гэрээний үнэнд өөрчлөлт оруулж болно.

## 4. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. **Захиалагч байгууллага, аж ахуйн нэгж нь ахуйн хортон шавьжийн идэвхитэй үржил, тархалтын ба халдварын үед өөрийн хүсэлтээр гэрээнээс гадуур захиалга өгч гэрээнд заасан нөхцөлүүдээр үйлчлүүлж болно.**

4.2. Гүйцэтгэгч байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг хангалтгүй гэж үзвэл үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг гаргах эрхтэй.

4.3. Захиалагч тал нь шавьж, мэрэгчийн тархалтыг үйлчлэгч байгууллагын мэргэжилтнүүдэд үнэн зөвөөр мэдээлж тандалт судалгаа дэмжиж гэрээнд заасан хугацаа, графикийн дагуу